

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН
ТАЛААРХ АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН**

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид "журам" гэх/-ын 12.1, 12.2, 12.3, 12.4-т заасны дагуу Ажлын хэсэг нь олонхын саналаараа Улсын Их Хуралд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн талаарх тайланг энэхүү загварт нийцүүлэн бичих үүрэгтэй. Журмын 13.1-д заасны дагуу Ажлын хэсгийн тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах тул уг тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Хүрэлбаатар Ургийн овог: Эрдэм Нэр: Эрдэм-Ундрах Хүйс: Эмэгтэй Төрсөн он: 1977 Төрсөн газар: Улаанбаатар хот, 1-р амаржих газар Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний алинд нэр дэвших тухай хүсэлт гаргасан талаар бичнэ. <i>Нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрах Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан.</i>
Сонгон шалгаруулалт, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга	
3	Нэгдүгээр үе шат Журмын 3.1.1-д заасны дагуу "сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх" үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. <i>Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-аар Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг Монгол Улсын Их Хурлаас нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулж томилохоор заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 4 гишүүнийг сонгон шалгаруулахаар 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл олон нийтэд нээлттэй зарлаж, холбогдох хүсэлт, материалыг хүлээн авахаар Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг баталсан.</i> <i>Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу сонгон шалгаруулалтын зарыг www.parliament.mn цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд нийтэд мэдээлсэн.</i>
4	Хоёрдугаар үе шат Журмын 3.1.2-д заасны дагуу "нэр дэвших тухай хүсэлт гаргах" үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. <i>Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож, хүсэлт, материалыг 21 хоногийн хугацаанд хүлээн авахаар нийтэд мэдээлсэн бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрах нь хүсэлт, холбогдох материалаа хугацаанд нь буюу 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр ирүүлснийг Байнгын хорооны ажлын алба хүлээн авсан.</i>
5	Гуравдугаар үе шат

	Журмын 3.1.3-д заасны дагуу “Ажлын хэсэг байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 14, 15 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны Хуулийн бодлогын хэлтсийн ахлах зөвлөх Г.Оргилболд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Х.Номингэрэл, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Амарсанаа, “Шихихутуг” их сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Нармандах, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Дөлгөөн нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Шүүхийн тухай хуульд Ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэгийг томилсон.
6	Дөрөвдүгээр үе шат Журмын 3.1.4-д заасны дагуу “нэр дэвшигчээр бүртгэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. Ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль болон Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д заасан материалын шаардлагыг хангасан гэж үзэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 25 хүнийг нэр дэвшигчээр бүртгэсэн. Ажлын хэсгийн энэхүү хуралдаанаар Х.Эрдэм-Ундрахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчээр бүртгэсэн.
7	Тавдугаар үе шат Журмын 3.1.5-д заасны дагуу “нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, асуулт, санал хүлээн авах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 8.1-д “нэр дэвшигчээр бүртгэснээс хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэсэн нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж түгээнэ.” гэж заасны дагуу дээр дурдсан 25 нэр дэвшигчийн материалыг www.parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан. Х.Эрдэм-Ундрахын Нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн байршуулсан.
8	Зургадугаар үе шат Журмын 3.1.6-д заасны дагуу “нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 10.1-д “Энэ журмын 9.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг нэр дэвшигчийг Ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж илтгэгч гишүүнийг томилно” гэж заасныг баримтлан 2025 оны 10 дүгээр сарын 22-

	ний өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар нэр дэвшигч тус бүрийн илтгэгч гишүүнийг сугалаагаар тодруулж, илтгэгч гишүүнийг томилсон. Нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрахын илтгэгч гишүүнээр Ажлын хэсгийн гишүүн С.Дондовыг сонгогдсон бөгөөд илтгэгч гишүүн Журмын 10.2-т заасан ажиллагааг явуулж холбогдох мэдээллийг цуглуулсан.
9	Долдугаар үе шат Журмын 3.1.7-д заасны дагуу “Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 11.1-д “Энэ журмын 10.7-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигч нь холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилгоор Ажлын хэсэг нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна.” гэж, 11.2-д “Ажлын хэсэг зургаагаас доошгүй тооны гишүүний ирцтэйгээр ярилцлага хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч даргална.” гэж заасан. Ажлын хэсгийн гишүүд 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Төрийн ордны “Их Засаг танхимд” нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрахтай ажлын хэсгийн ярилцлагыг зохион байгуулсан.
10	Наймдугаар үе шат Журмын 3.1.8-д заасны дагуу “нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгох” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 12.1-д “Энэ журмын 11.6-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.” гэж, мөн журмын 12.6-д “Энэ журмын 12.1-д заасан хуралдаанаас хойш ажлын гурван өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.” гэж заасны дагуу саналаа Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх зохицуулалттай. Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4.5-“энэ хуулийн 77.4.4-т заасан санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэл хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.” гэж заасан. Ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хуралдаж, илтгэгч гишүүн бүр өөрсдийн судалсан нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулж, ажлын хэсгийн бусад гишүүн саналаа хэлж, асуулт асууж хэлэлцсэн. Үүний дараагаар санал хураалтыг нууцаар явуулахад нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрахыг Ажлын хэсгийн найман гишүүн дэмжиж, олонхын санал авсан тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэрийг нь дэвшүүлэхээр шийдвэрлэсэн.
11	Сонгон шалгаруулалтын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь Ажлын хэсэг журмын 7.1-д заасан бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ, мөн журмын 12.4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт нь Шүүхийн тухай хууль болон энэ журмын дагуу явагдсан тухай нэгтгэн дүгнэж бичнэ. Ажлын хэсэг бүрэн эрхээ Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон журамд заасны дагуу хэрэгжүүлж, сонгон шалгаруулалтыг мөн хууль, журамд заасны дагуу зохион байгуулж явуулсан болно.
Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан тухай үнэлгээ Нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, нэр дэвшигчийн хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээлэл, олон нийтээс ирүүлсэн асуулт, санал, нэр дэвшигчийн талаар бусад	

хүмүүстэй хийсэн ярилцлага, нэр дэвшигчтэй илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн ярилцлага, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, нэр дэвшигчээс болон бусад этгээдээс гаргуулан авах зэргээр цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтад тулгуурлан нэр дэвшигчид тавих шаардлагыг яагаад хамгийн сайн хангасан гэж үнэлж дүгнэсэн тухайгаа журмын 12.4.3-т заасны дагуу ойлгомжтой, тодорхой бичнэ.	
12	Боловсрол Төгссөн их, дээд сургууль, коллеж, боловсролын зэрэг, төгссөн оноор нь хамгийн сүүлийнхээс нь эхлэн дараалуулж жагсааж, журмын 2.1.2, 2.2.2-д заасан шаардлагыг хангаж байгаа нь ямар мэдээлэл, нотлох баримтаар тогтоогдсон талаар бичнэ. Нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрах нь эрх зүйч мэргэжилтэй, Хууль зүйн докторын зэрэгтэй, Журамд заасан шаардлагыг бүрэн хангаж байна гэж үзэх үндэслэлтэй. Боловсролын байдлыг танилцуулбал тэрээр: 1. 2016 онд ХБНГУ-ын Фрайбург хотын Альберт-Людвигийн Их сургуульд Хууль зүйн ухааны докторын (Dr.jur) зэрэг хамгаалсан. 2. 2008-2014 онд ХБНГУ-ын Макс-Планк Нийгэмлэгийн (Max-Planck-Society) харьяа "International Max Planck Research School on Retaliation, Mediation and Punishment" (IMPRS-REMER) Олон улсын судалгааны сургуулийн докторантурт суралцсан. 3. 2002 - 2004 онд ХБНГУ-ын Фрайбург хотын Альберт-Людвигийн Их сургуульд Хууль зүйн магистрын зэрэг (LL.M) хамгаалсан. 4. 1999 - 2001 онд ХБНГУ-ын Фрайбург хотын Альберт-Людвигийн Их сургуулийн Герман хэлний бэлтгэл курст суралцаж төгссөн. 5. 1994 - 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг „Эрх зүйч” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Дээр дурдсан сургууль төгссөнийг гэрчлэх дипломын хуулбар, орчуулгыг тус тус хавсаргаж ирүүлсэн байна.
13	Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан тухай Журмын 2.1.2, 2.2.2-д заасны дагуу эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ. Нэр дэвшигч Др Х.Эрдэм-Ундрах нь 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөнөөс хойш 2025 оныг хүртэл мэргэжлээрээ ажилласан байх бөгөөд Журмын 2.1.2, 2.2.2-д заасны дагуу эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг бүрэн хангаж байна. Ажилласан байдал нь дараах баримтаар нотлогдож байна. Үүнд: 1. 2017.11.15-ны өдрөөс өнөөдрийг хүртэл МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимд Ахлах багш, Дэд профессор, Гэрээт дэд профессороор 8 жил. (Ажилд томилсон, чөлөөлсөн тушаалын хуулбар, НДШ төлөлтийн лавлагаа). 2. 2020.10.02 – 2025.04.24-ний өдрийг хүртэл Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захирал, 4 жил 7 сар (Ажилд томилсон, чөлөөлсөн тушаалын хуулбар, НДШ төлөлтийн лавлагаа). 3. 2017 - 2019 онд „Рендер“ ХХК-д Хуулийн зөвлөхөөр 2 жил (Ажлын газрын тодорхойлолт, НДШ төлөлтийн лавлагаа). 4. 2016.09.06 – 2018.01.15-ны өдрийг хүртэл ХЗҮХ-д Эрдэмтэн нарийн бичгийн дарга 1 жил 4 сар (Ажилд томилсон, чөлөөлсөн тушаалын хуулбар, НДШ төлөлтийн лавлагаа). 5. 2017 оны 5 дугаар сараас - 2018 оны 1 дүгээр сарын 15 хүртэл Швейцарийн хөгжлийн агентлагийн „Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр“-ийн хүрээнд хэрэгжүүлсэн "Иргэдийн оролцоо II" төсөлд Төслийн захирлаар 8 сар (НДШ төлөлтийн лавлагаа). 6. 2010.11 – 2015.5 дугаар сар хүртэл „Шпитц“ ХХК-д Хуулийн зөвлөх өөр 4 жил 6 сар (Ажлын газрын тодорхойлолт, НДШ төлөлтийн лавлагаа).

	7. 2010 - 2011 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн болон ЭБШЭЗ-н тэнхимд цагийн багшаар 9 сар (НДШ төлөлтийн лавлагаа). 8. 2005.02 – 2007.10 дугаар сар хүртэл ГТХАН-ийн (одоогийн GIZ) "Газрын менежмент, санхүүгийн кадастр" төсөлд Хуулийн зөвлөх (National long-term Law expert)-өөр 2 жил 8 сар (НДШ төлөлтийн лавлагаа). 9. 1998 - 1999 онд УАБХГ-ын БЗГ-т Дэд даргын туслахаар 1 жил 2 сар тус тус ажилласан байна. (Ажилд томилсон тушаалын хуулбар, Ажилд томилсон, чөлөөлсөнийг нотлох ТЕГ-ын тодорхойлолт)
14	Хууль зүйн өндөр мэргэшилтэй: хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай тухай Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ. Нэр дэвшигчийн эзэмшсэн боловсролын хувьд 2016 онд ХБНГУ-ын Фрайбург хотын Альберт-Людвигийн Их сургуульд Хууль зүйн ухааны докторын (Dr.jur) зэрэг хамгаалсан. 2008-2014 онд ХБНГУ-ын Макс-Планк Нийгэмлэгийн (Max-Planck-Society) харьяа "International Max Planck Research School on Retaliation, Mediation and Punishment" (IMPRS-REMER) Олон улсын судалгааны сургуулийн докторантурт суралцсан. 2002 - 2004 онд ХБНГУ-ын Фрайбург хотын Альберт-Людвигийн Их сургуульд Хууль зүйн магистрын зэрэг (LL.M) хамгаалсан. 1994 - 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг „Эрх зүйч” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн зэрэг үндэсний болон олон улсын хэмжээний хууль зүйн өндөр боловсрол эзэмшсэн гэж үзэх хангалттай үндэслэл юм. 2017-2025 он хүртэл МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимд Ахлах багш, Дэд профессор, Гэрээт дэд профессороор ажиллаж 2020-2025 хүртэл Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захирал, 2017 - 2019 онд „Рендер“ ХХК-д Хуулийн зөвлөхөөр ХЗҮХ-д Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Швейцарийн хөгжлийн агентлагийн „Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр“-ийн хүрээнд хэрэгжүүлсэн "Иргэдийн оролцоо II" төсөлд Төслийн захирал „Шпитц“ ХХК-д Хуулийн зөвлөх зэрэг ажил үүрэг гүйцэтгэж байгаа байдал, олон хууль бодлогын шинжтэй бичиг баримтад санал гаргаж ажлын хэсэгт ажилласан зэрэг нь ирүүлсэн материалаар хангалттай нотлогдож байна. Иймд хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн өндөр мэдлэг туршлагатай гэж үзэх бүрэн үндэслэлтэй гэж үнэлж байна.
15	Хууль зүйн өндөр мэргэшилтэй: мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан тухай Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ. Нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрахын ирүүлсэн материал, өөртэй нь болон бусад хүмүүстэй хийсэн ярилцлагын үр дүнгээс харахад урьд нь аливаа ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй, ярилцсан хүмүүсийн ихэнхи нь зан төлөв, ёс зүйн хувьд бүрэн төлөвшсөн хүн болохыг нь тодорхойлж байсан тул энэхүү шаардлагыг хангалттай гэж үнэлэв.
16	Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй тухай Журмын 2.1.3, 2.2.3-д заасны дагуу “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй” байх шаардлагыг хангаж байгааг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Х.Эрдэм-Ундрах 1977 онд төрсөн, 48 настай. Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй.
17	Монгол Улсын иргэн мөн тухай Журмын 2.1, 2.2-д заасны дагуу “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Төрийн үйлчилгээний цахим системийн Иргэний үнэмлэхийн лавлагаа, иргэний үнэмлэхний хуулбарыг үндэслэн Х.Эрдэм-Ундрах нь тус шаардлагыг хангаж байна.

18	Сүүлийн таван жилд улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй тухай Журмын 2.1.5, 2.2.4-д заасны дагуу “сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Х.Эрдэм-Ундрах нэр дэвшигчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт болон хавсралтаар ирүүлсэн бусад мэдээлэл, нотлох баримтад үндэслэв.</i>
19	Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Журмын 2.1.6, 2.2.10-д заасны дагуу “эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж байгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Х.Эрдэм-Ундрах нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй нь ял шийтгэлгүй талаарх тодорхойлолтоор нотлогдож байна.</i>
20	Сахилгын шийтгэлээр халагдаж эсхүл огцорч байсан эсэх тухай Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэхийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Х.Эрдэм-Ундрах нь сахилгын шийтгэлээр халагдаж эсхүл огцорч байгаагүйг ажилд томилсон, чөлөөлсөн тушаалын хуулбаруудад үндэслэв.</i>
21	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай Журмын 2.2.6, 2.3-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй буюу ажиллаж байгаагүй, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Х.Эрдэм-Ундрах нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй.</i> <i>/Нэр дэвшигчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт болон хавсралтаар ирүүлсэн бусад мэдээлэл, нотлох баримтад үндэслэв./</i>
22	Шүүгчээр ажиллаж байгаагүй тухай Журмын 2.1.4, 2.2.4, 2.2.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй байх, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчээр ажиллаж байгаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Х.Эрдэм-Ундрах нь шүүгчээр ажиллаж байгаагүй</i> <i>/Нэр дэвшигчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт болон хавсралтаар ирүүлсэн бусад мэдээлэл, нотлох баримтад үндэслэв./</i>
23	Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай Шүүхийн тухай хуулийн 95.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Х.Эрдэм-Ундрах нь Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, мөн ажиллаж байгаагүй бөгөөд энэ нь нийгмийн даатгалын дэвтрээр нотлогдож байна.</i>
24	Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.7-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Хамааралгүй</i>

25	Өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.8-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Хамааралгүй</i>
26	Прокуророор ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь прокуророор ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Хамааралгүй</i>
27	Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд санал болгох үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэх нь Ажлын хэсэг нь цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэлд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, ёс зүй, зан төлөвийг үнэлж журмын 2.1, 2.2, 2.3-д заасан харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хамгийн сайн хангаж буй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>Нэр дэвшигч Х.Эрдэм-Ундрах нь 2005-2025 онд дангаар болон бусадтай хамтарч бүтээсэн ном, гарын авлага 11, редактораар ажилласан 17 ном, судалгааны тайлангийн болон эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, хууль зүйн орчуулгын 6 ажил, докторын диссертацийн шүүмж 4, дангаар болон хамтран гүйцэтгэсэн 36 судалгааны талаарх мэдээлэл, гадаадад болон дотоодод хэвлэн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл 17, хэлэлцүүлсэн илтгэл 18 тус тус хавсаргаж ирүүлсэнтэй танилцлаа.</i> <i>Агуулгын хувьд эрүүгийн хариуцлага, ялын бодлого, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёо судлал, хүний эрх, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх асуудал, олон улсын гэрээ, конвенц ба эрүүгийн хуулийн нийцэл, төрийн хяналт, шалгалт, хуулийн этгээдийн төрөл, хэлбэр болон хариуцлага, хөдөлмөрийн зах зээл ба мэргэжлийн боловсрол, гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлал зэрэг голчлон нийтийн эрх зүйд хамаарах өргөн хүрээнд судалгаа, шинжилгээ хийсэн байна.</i> <i>Мөн бүх шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох нэр дэвшигчийн Эрүүгийн эрх зүйн тохиолдол шийдвэрлэх шалгалтын хариуг үнэлэхэд Шүүхийн мэргэшлийн хорооноос баримтлах ерөнхий аргачлалыг боловсруулах“ гэрээт ажлыг 2018 онд ШЕЗ-ийн захиалгаар хийж гүйцэтгэсэн туршлага зэргийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд тавигдах шаардлагыг хангаж байна гэж ажлын хэсэг үзсэн болно.</i>

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг
сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг**